



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ГЭР БҮЛ,
ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН ДАРГА НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44а,
Утас: 26-21-09, Факс: (976-51) 26-27-37,
E-mail: info@fcy.gov.mn, http://www.fcy.gov.mn

дод. 08.02 № 01/425
танай _____-ны № _____-т

Чиглэл хүргүүлэх тухай

Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/145, А/261 дүгээр хамтарсан тушаалаар Хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлэх ажлыг удирдлага зохицуулалтаар хангах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Хүүхэд харах үйлчилгээг цэцэрлэгийн хүртээмж багатай байршилд нэмэгдүүлэх, өргөжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлнэ үү. Үүнд:

1. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалтын дагуу хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг 08 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл бүртгэж, хүүхэд харагчийг бэлтгэх сургалтыг үндэсний сургагч багш нартай хамтран 08-р сарын 10-наас 08-р сарын 20-ны дотор зохион байгуулах;
2. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу орон нутгийн засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан "Хүүхэд харах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS6540:2015 стандарт"-ын хэрэгжилтэд үнэлгээ хийж, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох ажлыг 08-р сарын 25-ны дотор зохион байгуулах;
3. Засгийн газрын 2022 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журам"-ын 3.7-д заасны дагуу боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран хүүхэд харах үйлчилгээ болон сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн давхардлыг улиралд нэгээс доошгүй удаа шалгаж, тайлагнах;
4. Хүүхэд харагч болон хамрагдах хүүхдүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг мэдээллийн санд 09-р сарын 15-ны өдрийн дотор оруулсан байх;
5. Хүүхэд харах үйлчилгээний явцад хяналт тавих, Хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлэх, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх;
6. Эцэг эх, асран хамгаалагчтай хийсэн гэрээ, ирцийн бүртгэл, мэдээлэлд тулгуурлан санхүүжилтийн хүсэлтийг хуулийн хугацаанд, үйл ажиллагааны тайланг сар бүрийн 25-ны өдрийн дотор ирүүлж, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйгээр ханган ажиллахыг үүгээр чиглэл хүргүүлж байна.

Хавсралтаар: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/151 дүгээр тушаалын хуулбарыг хүргүүлж байна.

ДАРГА  БАТДОРЖ

